



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/94

Улаанбаатар хот


Гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрүүлэхгүй
буцаах тохиолдолд баримтлах заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйл, Байгууллагын даргын 2019 оны А/75 дугаар тушаалаар баталсан "Гадаадын иргэн, харьяатын газрын орон нутаг дахь газрын ажиллах журам"-ын 6.2, 6.3-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрүүлэхгүй буцаах тохиолдолд баримтлах заавар"-ыг 1 дүгээр, "Ярилцлага хийсэн тухай тэмдэглэл"-ийн загварыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Зааврын хэрэгжилтэд хяналт тавихыг Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэс /Л.Батсүх/-т, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Орон нутаг дахь газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.


ДАРГА



Д.МӨРӨН

000000423

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын
2019 оны 03 дугаар сарын 14 өдрийн
А/94 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



Гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрүүлэхгүй
буцаах тохиолдолд баримтлах заавар

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагч гадаадын иргэн, харьяалалгүй хүн /цаашид "гадаадын иргэн" гэх/-ийг улсын хилээр нэвтрүүлэхгүй буцаах тохиолдолд энэхүү зааврыг баримтална.

1.2. Гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрүүлэхгүй буцаахад Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан холбогдох журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

Хоёр. Гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрүүлэхгүй
буцаах ажиллагааг хэрэгжүүлэх

2.1. Албан хаагч "ISM" сүлжээ ашиглан гадаадын иргэний ирсэн зорилго, визийн ангилал, байх хугацаа, визийн төрөл зэрэгт өдөр тутам хяналт тавьж ажиллана.

2.2. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн холбогдох заалтыг үндэслэн гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрүүлэхгүй буцаах эсэхийг албан хаагч шийдвэрлэж, орон нутаг дахь газрын дарга хяналт тавьж ажиллана.

2.3. Монгол Улсын олон улсын гэрээний дагуу тодорхой хугацаагаар визгүй зорчих гадаадын иргэнийг хилээр нэвтрэхэд Монгол Улсад зорчих зорилго, урд нь тус улсад байсан хугацаа болон уригчтай эсэхийг тодруулан нэвтрүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

2.4. Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газраас төвийн зөвшөөрөлгүйгээр олгосон визтэй, Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацаа дуусаагүй гадаадын иргэн нэвтрэхээр ирсэн тохиолдолд байгууллагын даргын 2019 оны А/75 дугаар тушаалаар баталсан "Орон нутаг дахь газрын ажиллах журам"-ын 3.5, 3.6-д заасныг баримтлан ажиллана.

Гурав. Гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр
нэвтрүүлэхгүй буцаах ажиллагааг хэрэгжүүлэх дараалал

3.1. Гадаадын иргэн хилийн хяналт шалгалтын дараа ирсэн зорилгодоо нийцсэн визтэй эсэх, визийн ангилал, уригч байгууллагыг тодруулах зорилгоор түүний баримт бичгийг ISM програм ашиглан шалгаж, шаардлагатай тохиолдолд батлагдсан загварын дагуу орчуулгатайгаар ярилцлага хийж, хилээр нэвтрүүлэхгүй буцаахаар шийдвэрлэсэн тохиолдолд тэмдэглэлийг бүрэн гүйцэд бөглөж, бүрдүүлэх баримт бичгийн бүрдлийг хангана.

3.2. Гадаадын иргэнтэй ярилцлага хийж, улсын хилээр нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд тэмдэглэлийг бүрэн гүйцэд бөглөж, батлан даагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас баталгаа гаргуулан, түүний баримт бичгийн хуулбарыг хавсарган визгүй зорчих зөвшөөрөгдсөн хугацаанд буцаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана.

3.3. Ярилцлага хийхэд дуу, дүрсний бичлэг хийсэн тохиолдолд DVD хэлбэрээр холбогдох материалд хавсаргана.

3.4. Албан хаагч нь гадаадын иргэнийг буцаах үйл ажиллагааг виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, хяналтын улсын албан хаагч хил хамгаалах байгууллагын ажилтны хамт хэрэгжүүлэн ажиллаж тээврийн хэрэгсэлд суулган, хилээр буцаж гарах хүртэл хяналт тавьж ажиллана.

Дөрөв. Гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхгүй
буцаахад бүрдүүлэх баримт бичиг

4.1 Гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрүүлэхгүй буцаахад дараах материалыг бүрдүүлэн ажиллана:


- 4.1.1. ярилцлагын тэмдэглэл;
- 4.1.2. паспорт, түүнийг орлох баримт бичгийн нүүрэн болон визтэй хуудас, шаардлагатай бол бусад хуудсын хуулбар;
- 4.1.3. хэлмэрч хийсэн хүний биеийн байцаалтын хуулбар;
- 4.1.4. бусад шаардлагатай баримт бичгийн хуулбар.

4.2. Гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрүүлэхгүй буцаасан талаар бүртгэлийн дэвтэрт болон "ISM" сүлжээнд тухай бүр бүртгэл хөтөлнө.

4.4. Гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрүүлэхгүй буцаасан талаар өдөр тутмын мэдээ, сарын тайланд тусгах ба цахим хэлбэрээр орон нутаг хариуцсан нэгжид хүргүүлэн ажиллана.

-----oOo-----

Гадаадын иргэн харьяатын газрын даргын
2019 оны 03 дугаар сарын 11 өдрийн
А/94 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



ЯРИЛЦЛАГА ХИЙСЭН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

.....оны сарын.....өдөр

Дугаар

Гадаадын иргэн, харьяатын газрын дэх газрын /албан тушаал/.....,овогтой,.....би Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан холбогдох заалтыг үндэслэн гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх эсэхийг шийдвэрлэхээр дараах ярилцлагыг хийв.

1. Иргэний харьяалал

2. Овог, нэр, төрсөн он, сар, өдөр, паспорт /регистр/-ын дугаар

3. Хэлмэрчийн иргэний харьяалал, овог, нэр, паспортын дугаар

4. Иргэний давхар харьяалалтай эсэх

5. Тухайн жилд Монгол Улсад байсан нийт хугацаа

☐ 0-30 ☐ 31-60 ☐ 61-90 ☐ 91-180 ☐ 181-365

7. Монгол Улсад нэвтрэх визтэй эсэх

8. Визийн ангилал

☐ D ☐ A ☐ T ☐ O ☐ B ☐ S ☐ J ☐ HG ☐ SH ☐ TS ☐ H ☐ Визгүй нэвтрэх

9. Монгол Улсад ирсэн зорилго

10. Монголд Улсад байх хугацаа

11. Монгол Улсад байх хугацаанд зарцуулах хөрөнгийн эх үүсвэртэй эсэх

12. Уригч иргэн, аж ахуй нэгж, байгууллага байгаа эсэх /байгаа бол холбогдох мэдээлэл бичих/

13. Монгол Улсад байх хаяг

14. Холбоо барих утас

15. Асуулт:

Хариулт:

16. Асуулт:

Хариулт:

17. Асуулт:

Хариулт:

18. Танд нэмж ярих зүйл байна уу

19. Дүгнэлт:

20. Тухайн гадаадын иргэнийг хил нэвтрүүлсэн эсэх

☐ Тийм

☐ Үгүй

21. Шилжүүлсэн байгууллага, иргэний овог нэр, албан тушаал

22. Он, сар, өдөр, цаг, минут

23. Хил нэвтрүүлэлгүй буцаасан иргэний хөдөлгөөний төрөл, дугаар

26. Ярилцлага хийхэд дуу, дүрсний бичлэг хийсэн эсэх:

27. Ярилцлага ямар хэлээр явагдсан:

Тэмдэглэл үйлдсэн:/...../

Танилцсан:/...../

Хэлмэрчээр оролцсон:/...../